



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 06 өдөр

Дугаар А/191

Мандалговь

Зардал гаргах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2 дахь заалт, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 21 дүгээр тогтоолын 5 дугаар хавсралтын 2.3, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.1.4.1, 5.1.4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дэлхийн дулаарал, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах, газрын доройтол, цөлжилтийг сааруулах, экологийн тэнцвэрт байдлыг хангах, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлж байгаа олон талт ажлуудыг эрчимжүүлэх, "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг өрнүүлэх ажлын хүрээнд ӨМӨЗО-ны Ордос хотод "Уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтийг сааруулах туршлага судлах сургалт"-д шаардагдах зардлыг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

2. Сайнцагаан суманд улсын чанартай авто зам дагуу тарьсан модны хашааны шон, "Алимны мод тарих аргачлал", "Мод ногоон байгууламжийн арчилгаа, үрсэлгээ" сэдэвт сургалтын зардлыг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

3. Дээрх зардалд шаардагдах 16,622,500 (Арван зургаан сая зургаан зуун хорин хоёр мянга таван зуун) төгрөгийг аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн "Дундговьо ногооруулъя" төсөл арга хэмжээний зардлаас зарцуулахыг аймгийн Засаг даргын тамгын газар (Л.Доржбат), Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Энхтайван) нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА  Ц.МӨНХБАТ



4803100558